



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/261

Улаанбаатар хот

Дээд боловсролын салбарт хөгжлийн
бэрхшээлтэй иргэний сурч боловсрох
нөхцөлийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмчийн хэлбэр харгалзахгүй дээд боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах боломж, эрхийг бүрэн хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, тэднийг хөгжүүлэх, ажилд зуучлах чиг үүрэг бүхий албан хаагчийг ажиллуулсугай.


2. Дээд боловсролын сургалтын байгууллага нь 300-аас дээш оюутантай тохиолдолд орон тооны, 300-аас доош оюутантай тохиолдолд энэ тушаалын 1-т заасан чиглэлээр ажил хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гаргахыг захирал нарт даалгасугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 15.6 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-т дээд боловсролын салбарт хэрэгжүүлэхээр тус тус заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг их, дээд сургууль, коллежийн захирал нарт даалгасугай.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр батлагдсан хууль, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд боловсролын чиглэлээр батлагдахаар тусгагдсан журам, дүрэм, заавар, зөвлөмжийг боловсруулж, 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулахыг Дээд боловсролын бодлогын газар /Т.Амаржаргалан/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-очир/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулж, явцын тайлан мэдээллийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Дээд боловсролын бодлогын газар /Т.Амаржаргалан/-т үүрэг болгосугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА